



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 10 сарын 18 өдөр

Дугаар 1/453

Мандалговь

Хүүхдийн хөгжил хамгааллын жишиг
сургуулийг сонгон чадавхжуулах ажлын
хэсэг байгуулах тухай

Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, Засгийн газрын 2017 оны 270 дугаар тогтоолоор батлагдсан Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө (2018-2019)-ний 4 дүгээр зорилтын 4.1.1, аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.5.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Сургуулийн орчинд хүүхэд нэг бүрийг үл хайхрах, үе тэнгийн дарамт хүчирхийлэл, хүүхдийн эрүүл, аюулгүй сурч, боловсрох эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, хүүхдийн эсрэг хүчирхийллийн бүхий л хэлбэрийг таслан зогсоох, хамгаалах тогтолцоог бэхжүүлэх төдийгүй хүүхэд, эцэг эхчүүдийн оролцоонд тулгуурлан хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор Хүүхдийн хөгжил хамгааллын жишиг сургуулийг сонгон, чадавхжуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

-АЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга

Гишүүд:

-ГБХЗХГ-ын дарга

-АЗДТГ-ын Боловсрол, гэр бүл, хүүхэд залуучуудын асуудал хариуцсан мэргэжилтэн

-Мэргэжлийн хяналтын газрын Боловсрол, соёлын хяналтын улсын байцаагч

-Боловсрол, соёл, урлагийн газрын боловсрол, соёлын албаны дарга

-Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын хүүхэд хамгаалал, залуучуудын асуудал хариуцсан мэргэжилтэн

190010417

- Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын хяналт шинжилгээ үнэлгээ, захиргаа, хүний нөөц хариуцсан ахлах мэргэжилтэн
- Сонгогдсон сургуулийн захирал
- Сонгогдсон сургуулийн нийгмийн ажилтан
- Сонгогдсон сургуулийн хүүхдийн өөрөө удирдах байгууллагын төлөөлөл

Хоёр. Хүүхдийн хөгжил хамгааллын жишиг сургуулийг сонгон, чадавхжуулах ажлыг үр дүнтэй зохион байгуулж хэрэгжилтийг 2018 оны 4 дүгээр улиралд танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч, гишүүдэд үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ